УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2021 оны 08 сарын 26 өдөр Дугаар А/240 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар зүйлийн 3.1.10 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн ашиглалт засвар үйлчилгээ, Нэгдсэн удирдлагын системийн ашиглалтад хяналт тавьж ажиллах Төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль журамд нийцүүлэн зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Т.Хэрлэн)-нд даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/94 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

11103066

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 оны 08 сарын 26-ны өдрийн
А/210 дугаар тушаалын хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд	О.Батмөнх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	У.Сумъяа	Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо, 23-44 тоотын иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Ц.Болортунгалаг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн